МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/505 Есөнбулаг

## Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ойг тэмдэглэхтэй холбогдуулан Есөнбулаг сумын 10 багт нийтийн бие засах байгууламж нийлүүлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн дагуу хийгээгүй учир гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ойн тохижилт, бэлтгэл ажил хангах тухай" А/379 дугээр захирамжийг хүчингүй болгосугай.

3.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 100050051001 тоот дансанд төвлөрүүлэхийг "Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Э.Энхболд)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:Documents/ ZD A-4 doc

0201100790